

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 4 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 4 дүгээр сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1063 болж, 2015 мөн үеэс 320 хүнээр өсч, өмнөх сарынхаас 334 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 44.31 хувь буюу 471 нь эмэгтэйчүүд юм. 2016 оны эхнээс 319 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 247 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 36.44 хувь буюу 90 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1


Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 4 дүгээр сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр



Тайлант сард бүртгүүлсэн 438 ажилгүй иргэний 23.97 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 19.18 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 18.04 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 9.36 хувь нь шилжин суурьшсан; 9.13 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 3.42 хувь нь орон тооны цомхтголд орсон; 2.51 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 1.83 хувь нь цэргээс халагдсан; 1.14 хувь

нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1.14 хувь нь байгууллага татан буугдсан; 0.68 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.46 хувь нь хорих газраас суллагдсан; 7.08 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ. Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 4 дүгээр сарын эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 4 сард НДШ-ийн орлого 5.05 тэрбум ₮ болж төлөвлөгөө 96.46 хувь болж, төлөвлөгөөг 21 сум 0.89-59.26 хувиар давуулан биелүүлж. Архуст, Батсүмбэр, Баян, Баянчандмань, Эрдэнэ, Зуунмод сумд 25.1-4.32 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 347.4 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 12.8 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг

тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 262320 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 37.52 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 23.43%; тэтгэмжийн даатгалын сангийн 103.25%; эрүүл мэндийн даатгалын сангийн 151.43%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 107.12%; ажилгүйдлийн даатгалын сангийн 89.74%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 4 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 48391 хүнд олгож, 5.2 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 0.9 хувь 455 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 20.6 хувь 1.0 тэрбум ₮-өөр тус өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 101500 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 47.4 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 17.0 хувийг халамжийн тэтгэвэр; 5.9 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 4.9 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 1.3 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 2.2 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.6 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



1.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 4 сард 6385 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.54 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 4 сард 402 хүүхэд мэндэллээ.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



Аймгийн хэмжээнд он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 8 хүүхдээр өслөө.

Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн

4 дүгээр сарын байдлаар




2016 оны эхний 4 сард халдварт өвчнөөр 650 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 441 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс заг хүйтэн 1.45 дахин, салхин цэцэг 59.2 хувь, вируст гепатит 3.0 дахин, тэмбүү 61.67 хувь, улаан бурхан 36.4 дахин тус бүр өсчээ.

10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 71 байгаа бол: Зуунмод 189, Баян-Өнжүүлд 161, Баян 139, Архуст 126, Угтаал 83, Сумбэр 72 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



I.4 Байгаль орчин

Төв аймгийн 2016 оны 4 сарын цаг агаарын байдлыг олон жилийн дундажтай харьцуулсан тойм

1-нд нутгийн хойд хэсэг болон зарим газраар 0,0-0,6 мм, 6-нд нутгийн хойд хэсгээр 0,0-0,6 мм, 11,12-нд зарим газраар 0,0-0,6 мм, 13-нд нутгийн хойд хэсэг болон зарим газраар 0,0-3,0 мм, 15-нд нийт нутгаар 0,0-11,0 мм, 16-нд нутгийн зүүн хэсгээр 0,0-2,0 мм, 23-нд зарим газраар 0,0-0,6 мм, 24-нд Бүрэнд 0,3 мм, Дэлгэрхаанд 5,0 мм, 25-нд нутгийн зүүн хэсгээр 0,0-0,6 мм, 27-нд нутгийн хойд хэсгээр 0,0-4,0 мм, 30-нд нутгийн зүүн өмнөд хэсгээс бусад нутгаар 0,0-4,0 мм бороо, нойтон цас, цас оров.

Сарын нийлбэр тунадас 0.3-15.1 мм байна. Хамгийн их нь Борнуурт 15,1 мм, Жаргалантад 15,0 мм, Баянд 13,7 мм, Эрдэнэд 11.7 мм, харин Бүрэнд 0,3 мм буюу бага тунадас оржээ. Цасны зузаан өртөө харуулуудын талбай дээрх хэмжилтээр 1,8,11, 25-ний өдрүүдэд зарим газраар 0-1 см, 14-15-нд нийт нутгаар 0,0-11 мм нойтон цас, цас орж нутгийн баруун хойд хэсгээр 2-

23 см, хамгийн их нь Жаргалантад 23 см болсон ба 3-7 хоногийн дотор хайлж, 22-ны өдөр цасан бүрхүүлгүй болсон байна. Бусад хугацаандаа нийт нутгаар цасан бүрхүүлгүй байв. 12-нд зарим газраар, 15-нд ихэнх нутгаар нойтон цас, цас орж, цасан шуурга шуурсан нь цаг агаарын аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна.

Салхи ихэнх өдрүүдэд 6-11 м/с, 6-10,12,21,23,26,30-ний өдрүүдэд зарим газраар, 12,14-15,20-ны өдрүүдэд ихэнх нутгаар 18-20 м/с, түр зуур 23 м/с хүрч ширүүсэн, шороон болон цасан шуурга шуурав. Сарын ихэнх өдрүүдэд шөнөдөө 1-8 градус хүйтэн, өдөртөө 7-16 градус дулаан, 15-17-нд өмнөх хоногуудаасаа хүйтэрч шөнөдөө 9-15 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 6 градус дулаан, 20,26-30-нд дулаарч өдөртөө ихэнх нутгаар 15-22 градус дулаан, 29-нд зарим газраар 24 градус хүрч дулаарав.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

-агаарын дундаж температур ихэнх нутгаар бага зэрэг сэрүүн, зарим нутгаар ойролцоо

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь ихэнх нутгаар 6 градус орчмоор хүйтэн,

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн хүйтэн температур нь 8-9 градус орчмоор дулаан ажиглагдсан.

- Сарын нийлбэр тунадас 0.3-15.1 мм байна. Хамгийн их нь Борнуурт 15,1 мм, Жаргалантад 15,0 мм, Баянд 13,7 мм, Эрдэнэд 11.7 мм, харин Бүрэнд 0,3 мм буюу бага тунадас оржээ. Тунадасны хувьд өмнөх оныхоос газар тариалангийн бүс нутгийн зарим газраар өмнөх оны мөн үеэс ахиу, бусад нутгаар бага тунадас орж,

ихэнх хугацаандаа сэрүүвтэр, цаг агаар тогтворгүй, салхи шуурга ихтэй сар байлаа.

2016 ОНЫ ТАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сард агаарын дундаж температур уулархаг нутгаар 4 градус хүйтнээс 1 градус дулаан, бусад нутгаар 2-7 градус дулаан байх дунджийн орчим байх төлөвтэй.

Хүйтрэх үе. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе ба сүүлчээр хүйтэрч, уулархаг нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Сарын эцсээр хүйтэрнэ.

Дулаарах үе. Харин нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр харьцангуй дулаарч шөнөдөө уулархаг нутгаар 2-7 градус хүйтэн, бусад нутгаар 1 градус хүйтнээс 4 градус дулаан, өдөртөө голын хөндийгөөр 19-24 градус, бусад нутгаар 15-20 градус дулаан байна.

Бусад хугацаанд. Уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 11-16 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхээр зарим газраар, сүүлчээр нь ихэнх нутгаар цас, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим нутгаар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, сарын эцсээр ихэнх нутгаар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Энэ үеүдэд салхи зарим газраар 14-16м/с, ялангуяа нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр ба гуравдугаар арав

хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 18-20 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

4 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нутгийн нутгийн баруун өмнөд хагаст дунджаас дулаан, бусад нутагт дунджийн орчим, хур тунадас ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим ба түүнээс бага, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг болон говийн нутгийн өмнөд хэсгээр дунджаас ахиу орох төлөвтэй байна. 4 дүгээр сард дулаан, тунадас ахиу орох төлөвтэй нутгаар бэлчээрийн ургамал эрт цухуйж, хөрс эрт гэсэж газар тариаланд таатай нөөлөлөхөөр байна. Түүнчлэн 4 дүгээр сард үе үе хүчтэй цасан болон шороон шуурга шуурч малын хариулга маллагаа болон төл хүлээн авахад хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.



1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд 244 гэмт хэрэг бүртгэгдэж 230 хүн холбогдож иргэдийн өмчид 150.3 сая ₮-ийн хохирол учирлаа.


Гарсан гэмт хэргийн 44.3 хувь нь хулгай, 28.7 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 10.7 хувь нь замын осол, 5.3 хувь нь танхай дээрэм, 0.0 хувь нь хүн амины хэрэг, 0.0 хувь нь өмчийн, 11.1 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Алтанбулаг, Архуст, Баяндэлгэр, Баянчандсань, Сэргэлэн, Баянхангай, Баянжаргалан, Аргалант, Баян, Зуунмод сумд 18 дээш насны 10000 хүнд 73-32

гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (27)-оос харьцангуй их гарлаа.

Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 86 хэргээр буурлаа.

Зураг I.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар




Гарсан гэмт хэргийн 27.8 хувь нь бүлгээр; 30.0 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 99 хүн гэмтэж, 14 хүн нас барлаа.


Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 4 дүгээр байдлаар



Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 4 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 410 гүйцэтгэх хуудсанд нийт 2.21 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 6 гүйцэтгэх хуудсанд ногдох 494.1 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 404 гүйцэтгэх хуудасны 1.72 тэрбум ₮-өөс 128 хуудасны 213.0 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 31.68 хувь, үнийн дүнгээр 12.40 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 6.05 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 16.71 нэгжээр тус тус буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 4 сард кассын орлого 139.2 тэрбум ₮, кассын зарлага 104.6 тэрбум ₮ болж, гүйлгээнд 164.5 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 72714, зээлийн багцын дүн 235.0 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 24231, олгосон зээлийн дүн 47.2 тэрбум ₮ боллоо.

Иргэдийн хувийн хадгаламжинд 4 сарын 30-ны байдлаар хугацаатай хадгаламж 45.5 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 11.3 тэрбум ₮ байна.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 0.76-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 14.3 хувь буюу 362.3 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 89.2 хувийг татварын, 9.8 хувийг татварын бус, 1.0 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 10.1 нэгжээр өсч, татварын бус орлого 10.7 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.6 нэгжээр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 3677.8 сая ₮ болж аймгийнх 2545.7 сая ₮ буюу 69.2 хувь, сумынх 354.5 сая ₮ буюу 9.6 хувь, улсынх 777.6 сая ₮ буюу 21.1 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 19.7 хувь буюу 191.8 сая ₮-өөр өсч 1.1 тэрбум ₮ болж, авлага 1.5 дахин буюу 248.8 сая ₮-өөр өсч 406.2 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 2.9 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 92.8 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 354.5 сая ₮ болж, төлөвлөгөө 84.1 хувь биелж, Угтаал, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Баянхангай, Баян, Сэргэлэн, Заамар, Баянцагаан, Аргалант, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэсант, Борнуур, Зуунмод, Бүрэн, Архуст, Жаргалант,

Эрдэнэ, Сүмбэр сумд 77.1-5.0 хувиар тасалдууллаа. Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 2.5 тэрбум ₮ болж 98.1 хувь биелж Баянцагаан, Жаргалант, Эрдэнэ, Өндөрширээт, Баян, Баянцогт, Угтаал, Алтанбулаг, Баянхангай, Баяндэлгэр, Архуст, Зуунмод, Эрдэнэсант, Сүмбэр, Баянчандмань, Баянжаргалан, Борнуур, Дэлгэрхаан, Мөнгөнморьт сумд төлөвлөгөө 44.4-0.2 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 4 дүгээр сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 66.49%, өмнөх оны мөн үеэс 6.09%, өмнөх сараас 1.16 хувиар тус тус өсөв.

Зураг II.4

Хэрэглээний үнийн аймгийн индекс
(өмнөх оны 12 сар=100)



ХҮИ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 1.16 хувийн өсөлтийн 1.06 нэгж (91.14%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн; 0.05 нэгж (4.16%) нь тээврийн бүлгийн; 0.02 нэгж (1.41%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0.01 нэгж (1.02%) нь согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн; 0.02 (2.01%) нэгж нь бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаав.

Барга, үйлчилгээний бүлэг	2016 оны 4 сард	
	пунктээр	хувьд
Бүгд	1.16	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БҮС ҮНДАА	1.06	91.14%
02. СОГТУУРУУЛАХ ҮНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.01	1.02%
03. ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	0.02	1.41%
04. СРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00	0.00%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.00	0.27%
06. ЭМ, ТАРИА, ЗМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.05	4.16%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	2.01%



II. Төл бойжилт

5 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 60.4 хувь 1201.8 мянган хээлтэгч мал төллөж, 1201.9 мянган төл гарсны 97.7 хувь 1183.2 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 5.5 хувь буюу 71.1 мянгаар; бойжиж буй төл 5.0 хувь 62.5 мянгаар буурч; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 34.6 хувь 308.9 мянгаар, бойжиж буй төл 25.6 хувь 318.4 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 29.1; гүүний 18.1; үнээний 30.9; эм хонины 66.9; эм ямааны 62.4 хувь нь тус бүр төллөв.

Гарсан төлийн 2.3 хувь 27765 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 17.2 хувь буюу 5761 төлөөр; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 18.1 хувь буюу 6129 төлөөр буурлаа. Гарсан ботгоны 0.9, унаганы 3.8, тугалын 2.7, хурганы 1.8, ишигний 3.0 хувь нь тус бүр хорогдов. Хамгийн их хорогдолтой 5 сум Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Өндөрширээт, Лүн, Алтанбулаг сумд гарсан төлийнхөө 3.6-2.2 хувь буюу 3961-2201 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 65.5 хувийг (бүгд 18178 төл) эзлэв.

Том малын зүй бус хорогдол

5 сарын 1-ний байдлаар оны эхний малын 1.6 хувь буюу 69118 том мал зүй бусаар хорогдсон нь 2015 оны мөн үеэс 1.5 дахин буюу 41681 толгойгоор; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 3.8 хувь буюу 2558 толгойгоор тус бүр өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянцогт, Эрдэнэсант, Бүрэн, Баян-Өнжүүл, Лүн сумд оны эхний малынхаа 11.71-1.72 хувь буюу 12645-4657 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 60.3 хувь (бүгд 41706) эзлэв.

Оны эхний тэмээний 0.5, адууны 1.3; үхрийн 2.4; хонины 1.2; ямааны 2.0 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 4.9 хувь нь өвчнөөр, 30.3 хувь нь хээлтэгч мал эзлэв.



II.5 Аж үйлдвэр

2016 оны эхний 4 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 2.25 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 44.3 хувь буюу 1.79 тэрбум ₮-өөр буурлаа.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая ₮-ээр
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015 IY	2016 IY	2015 I-IY	2016 I-IY	Дүнд зэрэгц Percentage share to total		2016% 2015%
					2015 I-IY	2016 I-IY	
Нийт дүн	2,140.46	1,209.34	4,054.09	2,257.49	100.0	100.0	55.7%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	1,691.29	873.83	1,762.54	887.77	43.48%	39.33	50.4%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing	255.14	131.76	1,372.50	696.06	33.85	26.85	44.2%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy/steam	194.04	203.74	919.05	763.67	22.7	33.83	83.1%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод,

модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл, хэвлэн нийтлэх, цахилгаан дулааны үйлдвэрлэл өмнөх оноос 92.6-8.7 хувь буюу 411.69-5.15 сая ₮-өөр буурсан нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, эзлэх хувь



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэ, Баянцагаан, Угтаалцайдам сумд 55.69-2.01 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 80.1) хувийг

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, хувиар




II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2016 оны эхний 4 сард 79.0 сая ₮-ийн их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2015 оны

мөн үетэй харьцуулахад 4.5 дахин буюу 357.0 сая ₮-өөр буурав.

Зураг II.8 Барилга угсралт, их засварын ажил жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, сая.₮




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 4 сард 61.06 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 27.77 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.45 хувь буюу 5.6 сая ₮-өөр буурлаа. Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 31.9 сая ₮ болсон ба нийт орлогын 79.7 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 20.30 хувийг албан бичгийн, 11.38 хувийг зорчигчдын, 68.32 хувийг бусад орлого бүрдүүлээ

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 4 сард нийт 1021 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 42; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 1; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 416; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 11; бэлэглэлийн гэрээ 25; худалдах, худалдан авах гэрээ 52; өв залгамжлал 4; барьцааны гэрээний бүртгэл 294; бусад бүртгэл 176 тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 4 сард нийт 52 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 30 ; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 9; шашин 2; боловсрол сургалтын байгууллага /БСБ/ 1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 4; шашин 3; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 3; Төсөвт 2 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 4 сарын мэдээгээр 101 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 17; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 18; дүрэм шинчилсэн 3; дахин гэрчилгээ 7; удирдлага өөрчлөгдсөн 15; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 8; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 13; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр өөрчлөгдсөн 8; татан буугдсан 10; тус бүр бүртгүүллээ. Мөн 30 иргэн, 8 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 4 сарын мэдээгээр нийт 42 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 227; үүнээс тохирлын гэрчилгээ 187, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 40; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 1198; үүнээс цулын хэмжүүр 274, жин 224, туухай 49, автомашины жин 1; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 96; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 53, мерник 4, сүмбэн метр 8, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 3, уртын хэмжих хэрэгсэл 3, усны тоолуур 3; нэг фазын тоолуур 806, гурван фазын тоолуур 22; даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.